



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 06 өдөр

Дугаар A/28

Улаанбаатар хот

### “Павер экспо” авто фестиваль зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, “Павер экспо” авто фестиваль зохион байгуулах тухай нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/558 дугаар захирамж, газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгон нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Павер экспо” авто фестивалийг 2023 оны 06 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд Авто худалдааны цогцолборт зохион байгуулсугай.

2. “Павер экспо” авто фестивалийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 49,251,929 /дөчин есөн сая хоёр зуун тавин нэгэн мянга есөн зуун хорин ес / төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА  Д.Батсүх

1150500150

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2023 оны 06 сарын 06 өдрийн  
А.128 дугаар тушаалын хавсралт

“ПАВЕР ЭКСПО” АВТО ФЕСТИВАЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Зохион байгуулалтын арга хэмжээ				
1	НОБГ-с үйл ажиллагаанд хамгаалалтад үүрэг гүйцэтгэх албан хаагчдын хоол, гал түймэр унтраах, аврах ажиллагаа, шуурхай албаны автомашинуудын шатахууны зардал төсөв	Багц	1,666,479	1,666,479
2	Хот тохижилтын газраас Био 00 ашиглуулах, бохир соролтын зардал	28ш	9,831,750	9,831,750
3	Хот тохижилтын газраас зам цэвэрлэгээний машины зардал	Багц	5,040,500	5,040,500
4	Монгол наадам цогцолбор-с сандал түрээсийн зардал	Багц	28,000,000	28,000,000
5	НЭМГ-с түргэн тусламжийн баг ажиллуулах зардал	Багц	2,992,000	2,992,000
6	120 самбарт сурталчилгааны анонс байршуулах зардал	3 өдөр	1,721,200	1,721,200
Дүн				49,251,929

--- оОо ---